

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Ч.МӨНХТУЯА  
2024 оны 10 дугаар сарын 08 -ны өдөр



**НИСЭХИЙН ХОЛБОО, НАВИГАЦИ, АЖИГЛАЛТЫН АЛБАНЫ  
ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫН АЖЛЫН ТУСГАЙ  
ХУВЦСАНД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Тус албаны инженер, техникийн ажилтнуудын өвөл, зуны гадуур хүрэм, өмд, гутал, өвлийн малгай цаашид “Ажлын тусгай хувцас гэх”-д тавигдах шаардлага, хувцасны загварыг оруулсан болно.




### 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


- 2.1 Ажлын тусгай хувцас нь MNS ISO 13688:2000 “Хөдөлмөр хамгааллын хувцас- Ерөнхий шаардлага”, MNS 5623:2006 “Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал”, ISO 20345:2011 “Ажлын хамгаалалттай гутал”, EN 342:2017 “Хүйтэн нөхцөлд өмсөх ажлын хувцас” стандартуудад дүйцэхүйц шаардлагыг бүрэн хангасан байна.
- 2.2 Тендерт шалгарсан компани нь захиалагч талд жишиг хувцас хийж, үзүүлэн ярилцаж тохиролцсоны дараа ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэнэ.
- 2.3 Тендерт оролцож байгаа компани нь хувцсанд орох материалын дээжээс тендерийн бичиг баримттай хамт ирүүлнэ.
- 2.4 Ажлын тусгай хувцас нь техникийн үзүүлэлт хэсэгт тусгасан шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай бөгөөд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ. Үүнд:
  - 2.4.1 Үйлдвэрлэлийн гарал үүслийн гэрчилгээ
  - 2.4.2. Тендерт шалгарсан нийлүүлэгч нь нийлүүлэх бүх хувцасны загварыг үндсэн болон туслах материалын биет каталогийг эскиз зургийн хамт гэрээ хийхээс өмнө захиалагчид ирүүлнэ.
  - 2.4.3. Тендерт шалгарсан хувцас болон үндсэн, зарим туслах материалын загварыг захиалагч авч үлдэх бөгөөд энэ нь нийлүүлэх бусад хувцсыг шалгах загвар /эталон/ болно.




### 3. БАТАЛГААТ ХУГАЦАА


3.1. Захиалагч тал ажил хүлээн авах актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 6 сараас доошгүй байна.

#### 4. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| №                   | Материал                     | Шаардлага  | Загвар   |
|---------------------|------------------------------|--|--|
| <b>ӨВЛИЙН ХҮРЭМ</b> |                              |  |  |
| 1                   | Үндсэн материал /гадна өнгө/ | <p>100% амьсгалах боломжтой полиестер, цахилгаанжихгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Хар хөх өнгөтэй.</p> <p>Ажлын хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь ажлын нөхцөлд хүнд саад болохгүй байх.</p> <p>Хүний биед хүрэлцэхүйц хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсэхгүй, ширүүн, хурц ирмэггүй байх.</p> <p>Хувцасны дизайн нь өвлийн улиралд хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх.</p> | <p>Урд талаас нь харуулсан зураг</p>  |
| 2                   | Дотор                        | <p>Хүрэмний дундуур ба дотор талаар (доод халаасны дээгүүр) бүс хийх.</p> <p>Дотор өмсөж буй хувцастай үрэлт үүсгэхээргүй материалтай нэмэлт салдаг дотортой байх.</p>   | <p>Ар талаас нь харуулсан зураг</p>  |
| 3                   | Дотрын материал              | Дулаан хадгалах чадвар сайтай, хөнгөн чанартай, зориулалтын өнгө дагуу дотрын материалаар хийгдсэн байх.   |  |
| 4                   | Юүдэн                        | Юүдэн нь хүрэмнээс салдаг цахилгаантай байх.   |  |
| 5                   | Зах                          | Босоо захтай, хацар, хүзүү хайрахгүй материалтай байх. Өндөр 10 см   |  |
| 6                   | Энгэр                        | Аливаа зүйлд татагдахгүй, орооцолдохгүй сайн чанарын цахилгаантай, цахилгааны дээд, доод хэсэгт 2 кнопон товч бүхий цахилгаан далдлагчтай байх. Далдлагчийн өргөн 7-8 см   |  |
| 7                   | Халаас                       | <p>Энгэрийн зүүн (гадна) талд ил халаастай, халаасны амсрыг далдалсан таг хэсэг нь наалддаг хийцтэй байх. Өргөн 14-15 см, өндөр 16-17см</p> <p>Цээж хэсгийн баруун, зүүн доод талд ил халаастай, халаасны дээд амсрыг далдалсан таг хэсэг нь наалддаг хийцтэй байх. Мөн ил халаасны хажуу хэсэг давхар халаастай байх. Өргөн 18 см, Өндөр 20см</p>   |  |
| 8                   | Тэмдэглэгээ                  | Энгэрийн зүүн халаасны дээд хэсэгт албаны логог өнгө ялган   |  |

|                   |                 |  |  |
|-------------------|-----------------|--|--|
|                   |                 | оёсон байх. Логоны хэмжээ 6х6 см   |  |
|                   |                 | Энгэрийн баруун халаасны дээд хэсэгт албаны товчилсон нэр “CNS”-ийг оёсон байх. Үсэгний хэмжээ 3х3 см, мөнгөлөг саарал   |  |
|                   |                 | Ар талд 2 далны хооронд ATSEP-ийг оёсон байх.Үсэгний хэмжээ 10х4 см; мөнгөлөг саарал /дармал том үсгээр/   |  |
| 9                 | Ханцуй          | Ханцуй нь бугуй хэсэгтээ резинэн оруулгатай (гарын хуруу хүртэл бээлий маягийн) байх.  |  |
| 10                | Гэрэл ойлгогч   | Урд талд: Энгэрийн баруун зүүн халаасны дээд талаар хэвтээ чиглэлтэй халаасны хэмжээгээр 5см өргөн гэрэл ойлгогчтой байна. Ар талд: Ар талын гэрэл ойлгогчийг урд талын гэрэл ойлгогчтой ижил түвшинд байрлуулна. Мөнгөлөг саарал Энгэрийн халаасны дээгүүр халаасны эмжээртэй параллель байна. Гэрэл ойлгогчны өргөн 5см байна. |  |
| <b>ӨВЛИЙН ӨМД</b> |                 |  |  |
| 1                 | Үндсэн материал | 100% амьсгалах боломжтой полиестер, цахилгаанжихгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Хар хөх өнгөтэй.   |  |
| 2                 | Дотрын материал | Дулаан хадгалах чадвар сайтай, өмсөж тайлахад хялбар, дотор өмсөж буй хувцастай үрэлт үүсгэхгүй байх.  |  |
| 3                 | Халаас          | Ташааны 2 талд ташуу чиглэлтэй. Халаасны ташуу 10 хэм халаасны гүн 17см<br>Гуяны хажуу хэсэгт 2 халаас байх ба тэгш өнцөг хэлбэртэй, дээд талдаа цахилгаантай байх. Халаасны хэмжээ 17х17см<br>Өмдний арын хэсэгт 2 ширхэг байх. Халаасны хэмжээ 13х13см   |  |
| 4                 | Мөрөвч          | Өмдний мөрөвч нь хүний биений далны доод тал хүртэл битүү өөрийн биеийн хэмжээнд тааруулахаар тохируулагчтай байх. Мөрөвчний өргөн 6см   |  |
| 5                 | Гэрэл ойлгогч   | Хөлний шилбэний хэсэгт бүтэн тойрсон 5 см өргөнтэй гэрэл ойлгогчтой байх. Мөнгөлөг саарал  |  |

| ЗУНЫ ХҮРЭМ |                 |  |   |
|------------|-----------------|--|---|
| 1          | Үндсэн материал | 65% полиэстер, 35%, хөвөн даавуу цахилгаан дамжуулдаггүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Хар хөх өнгөтэй байх.   | <p>Урд талаас нь харуулсан зураг</p>  <p>Ар талаас нь харуулсан зураг</p>  |
| 2          | Зах             | Хүзүү холгохооргүй, зөөлөн даавуун материалтай, өндөр 8-10 см, нугалж өмсөхөөр байх.   |   |
| 3          | Хормой          | Хүрэмний доод хэсэг монжаткатай, хоёр хажуу талдаа зориулалтын резинтэй байх. Монжатканы өргөн 6см   |   |
| 4          | Халаас          | Энгэрийн гадна баруун, зүүн талд ил байрлах халаастай, дээшээ босоо чиглэлтэй өнгө ялгасан цахилгаантай байх. Өргөн нь 14см, өндөр нь 16см   |   |
|            |                 | Энгэрийн гадна баруун, зүүн доод /ташаа/ талд халаастай, халаасны амыг дарсан цахилгаантай байх. Өргөн 16см, Өндөр 18см  |   |
|            |                 | Баруун, зүүн доод /ташаа/ дотор талд халаастай байх. Өргөн 16см, Өндөр 18см  |   |
| 5          | Агаар сэлгэгч   | Дал, суга, нурууны дээд босоо хэсэгт агаар чөлөөтэй сэлгэж байхаар торон даавуугаар суналттай оруулга оёсон байх. өндөр 25 см  |   |
| 6          | Гэрэл ойлгогч   | Урд талд: Энгэрийн хоёр халаасны дээд талд мөр дагасан, ар талд хөндлөн гэрэл ойлгогчтой байх. Мөнгөлөг саарал Энгэрийн халаасны дээгүүр халаасны эмжээртэй паралель байна. Гэрэл ойлгогчны өргөн 3 см |   |
| 7          | Ханцуй          | Ханцуйн монжат нь ихэсгэж богиносгох зориулалтын зангуутай байх. Монжатын өргөн нь 4см   |   |
| 8          | Тэмдэглэгээ     | Энгэрийн зүүн дээд халаасны дээд хэсэгт албаны логог өнгө ялган оёсон байх. Хэмжээ 6x6 см                          |   |
|            |                 | Энгэрийн баруун дээд халаасны дээд хэсэгт албаны товчилсон нэр "CNS"-ийг оёсон байх. Хөх өнгөтэй. Үсэгний хэмжээ 2,5x2,5 см  |   |
|            |                 | Ар талд 2 далны хооронд ATSEP-ийг оёсон байх. Үсэгний хэмжээ 10x4 см, мөнгөлөг саарал /дармал том үсгээр/  |   |
| ЗУНЫ ӨМД   |                 |  |   |
| 1          | Үндсэн материал | 65% полиэстер, 35%, хөвөн даавуу цахилгаанжихгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Хар хөх өнгөтэй байх.   | Урд, ар талаас нь харуулсан зураг   |
| 2          | Халаас          | Өмдний баруун, зүүн талд 2 ширхэг, ташуу чиглэлтэй, цахилгаантай халаас байх.  |   |


|   |                     |   |   |
|---|---------------------|---|---|
| 3 | Нэмэлт              | Өвдөгний болон өгзөгний хэсгээр өөрийн өнгөөр давхарласан оруулгатай байх.                              |  |
| 4 | Нэмэлт материал     | Өвдөгнөөс дээш саарал, өвдөгнөөс доош хар өнгөтэй байх.   |   |
| 5 | Гэрэл ойлгогч       | Өмдний доод шуумагнаас дээш 30 см хэсэгт бүтэн тойрсон гэрэл ойлгогчтой байх. Мөнгөлөг саарал өргөн 3см |   |
| 6 | Нэмэлт /хүрэм, өмд/ | Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх.           |   |

#### ӨВЛИЙН ГУТАЛ

|   |                 |   |  |
|---|-----------------|---|--|
| 1 | Гутлын стандарт | Ажлын тусгай гутлын ерөнхий шаардлага олон улсын стандарт   |  |
| 2 | Гадна тал       | Сайн чанарын шир, арьсан материалтай, 30 см орчим өндөр түрийтэй, түрийний дээд хэсэгт цас, хог орохоос хамгаалсан даавуун хамгаалалттай байх. /ХАР, БОР/ |  |
| 3 | Дотор тал       | Ус, чийг татахгүй. Доторлогоотой, нэхий дотортой, даацын цохилт даах чадвартай хуванцар хамгаалалттай байх.   |  |
| 4 | Хамгаалалт      | 200 джоулын механик биетийн цохилтыг даах цахилгаанждаггүй, полимер хамгаалалттай.  |  |
| 5 | Ул              | Хөлд эвтэйхэн нумтай, статик цахилгаан дамжуулахгүй, хальтрахгүй, -40°C хэмд хөлдөхгүй, тос, хүчилд тэсвэртэй байх.                                       |  |

#### ЗУНЫ ГУТАЛ

|   |                   |  |  |
|---|-------------------|--|--|
| 1 | Гутлын стандарт   | Ажлын тусгай гутлын ерөнхий шаардлага олон улсын стандарт  |  |
| 2 | Гутлын гадар      | Ус нэвчдэггүй бүрэн боловсруулсан 2,1 мм-ийн зузаантай цэвэр ширэн материалтай байх./ ХАР, БОР/  |  |
| 3 | Гутлын хамгаалалт | <ol style="list-style-type: none"> <li>200 джоулын механик үйлчлэлээс хамгаалах, хөнгөн, металл бус полимер хамгаалалттай байх.</li> <li>Хатгалтаас хамгаалсан дунд ул нь металл бус орчин үеийн технологийн, нэхмэл утастай байх.</li> <li>Өсгий болон хоншоорын сайжруулсан хамгаалалт нь элэгдлийн эсрэг хамгаалалттай байх ба шаардлагатай үед үрэлт, зүсэлтийн нөлөөг бууруулдаг байх.</li> </ol> |  |

|                    |              |   |  |
|--------------------|--------------|---|--|
| 4                  | Гутлын дотор | 1. Зөгийн үүр шиг бүтэцтэй 3D доторлогоотой байх ба энэ нь хөлний амьсгалах чадварыг нэмэгдүүлж, хөлсийг түргэн шингээх, хатаах зориулалттай байх.<br>2. Гутлын түрий хэсэг болон хэл нь хөлийг тав тухтай байлгах зорилгоор зөөлөвчилсэн байх.   |  |
| 5                  | Гутлын ул    | 1. Элэгдэлд тэсвэртэй гулгалтын эсрэг өндөр үзүүлэлт бүхий 2D цутгамал ултай, бензин тос, хүчилд тэсвэртэй байх.<br>2. Хатгалтаас хамгаалсан дунд ул нь металл бус орчин үеийн технологийн, нэхмэл утастай байх. Дотор ул нь цахилгаанждаггүй, хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хөлийн хөдөлгөөнийг хязгаарлахгүй, хөнгөн уян налархай байх. |  |
| <b>ЗУНЫ МАЛГАЙ</b> |              |   |  |
| 1                  |              | Саравчтай цохилтын хүчийг саармагжуулах хамгаалалтын малгай. Полиамид материалаар хийгдсэн.   |  |

Нийлүүлэх хувцасны тоо хэмжээ


| Ажлын тусгай хувцас | Өвлийн хувцас |     | Өвлийн гутал |     | Зуны хувцас |     | Зуны гутал |     | Зуны малгай |     |
|---------------------|---------------|-----|--------------|-----|-------------|-----|------------|-----|-------------|-----|
|                     | хэмжээ        | тоо | хэмжээ       | тоо | хэмжээ      | тоо | хэмжээ     | тоо | хэмжээ      | тоо |
| Хэмжээ, тоо         | 44            | 5   | 37           | 3   | 42          | 2   | 36         | 3   |             | 50  |
|                     | 50            | 6   | 38           | 3   | 44          | 7   | 37         | 4   |             |     |
|                     | 52            | 9   | 40           | 2   | 46          | 7   | 38         | 5   |             |     |
|                     | 54            | 2   | 41           | 1   | 48          | 14  | 39         | 3   |             |     |
|                     | 56            | 2   | 42           | 6   | 50          | 20  | 40         | 16  |             |     |
|                     |               |     | 44           | 2   | 52          | 12  | 41         | 10  |             |     |
|                     |               |     |              |     | 54          | 8   | 42         | 18  |             |     |
|                     |               |     |              |     | захиалах    | 1   | 43         | 8   |             |     |
|                     |               |     |              |     |             |     | 44         | 2   |             |     |
|                     |               |     |              |     |             |     | 45         | 2   |             |     |
| <b>Нийт дүн</b>     | <b>24</b>     |     | <b>17</b>    |     | <b>71</b>   |     | <b>71</b>  |     | <b>50</b>   |     |

## 6. ХҮЛЭЭН АВАХ

6.1. ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь ажлын тусгай хувцсыг энэхүү техникийн тодорхойлолтод тусгасан шаардлагын дагуу шалган, хүлээж авах ба акт үйлдэн, 2 тал гарын үсэг зурж баталгаажуулна.

### Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэхийн,  
холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга  
Үнэлгээний хорооны дарга:



Г.Баттөгс

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөдөлмөрийн  
аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэсийн мэргэжилтэн  
Үнэлгээний хорооны гишүүн:



Ч.Даваажав

“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн,  
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Г.Ганчимэг

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”  
Төрийн бус байгууллагын гишүүн,  
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Б.Мэндсайхан

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн мэргэжилтэн,  
Үнэлгээний хорооны нарийн бичиг:



Д.Насандэлгэр